



ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТЫН АРГАЗҮЙ

МУБИС-ийн ТНУС-ийн Философи, дидактикийн тэнхимийн багш О.Өнөрцүцэг

Abstract

The key issue of rights based education is violence prevention in the curriculum and its implementation in the educational settings. Violence prevention in the curriculum is significant program to developing of Child Friendly School. This curriculum must be including following three curriculum:

- Violence prevention in the curriculum (6-10 age)
- Violence prevention in the curriculum (10-14 age)
- Violence prevention in the curriculum (14-18 age).
- Хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэж буй аливаа хичээлийн хөтөлбөр нь:
 - соёлын ялгаатай байдлыг ойлгох, хүлцэн тэвчих,
 - энх тайван, шударга ёсыг дээдлэх,
 - хариуцлагатай иргэн болон төлөвших,
 - бусадтай эв зүйгээр, эерэгээр харилцдаг,
 - өөрийгөө зөвөөр илэрхийлж чаддаг,
 - олон нийтийн дунд зохистойгоор биеэ авч явж чаддаг
 - өөрийгөө болон бусдыг хүндэтгэдэг бие хүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн байна. Эдгээр зорилтуудыг нийгэм-хүмүүнлэг, байгалийн ухаан, математик, урлаг зэрэг бүхий л судлагдахууны сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлэх бололцоотой байдаг байна.

Тэгэхээр хүчирхийлэлгүй сургуулийн бодлогыг хэрэгжүүлж буй аливаа сургууль нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн интеграцчилсан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарах ёстой байна. Уг интеграцчилсан хөтөлбөрийн

Зорилго: хүний эрх, энх тайван, хүлцэл тэвчил, шударга ёс, хүнлэг, энэрэнгүй ёс зэрэг үнэт зүйлсэд анхаарсан байна. Түүнчлэн сургалтын үр дүнд дараах чадварууд хүүхдэд төлөвшсөн байх ёстой гэж үзнэ. Үүнд:

- Ямар үйлдлүүд хүчирхийлэл болохыг нэрлэх,
- Хүүхдийг үл хайхарна гэдгийг өөрийн үгээр тодорхойлох,
- Хүчирхийллийн хэлбэрүүдийг ялган таних,
- Өөрт тохиолдож буй тааламжгүй асуудлууд нь хүчирхийлэл мөн эсэхийг ялгах,

- Хүчирхийллийн гомдол маргаан үүсгэхэд шүүх эмнэлгийн магадалгаа ихээхэн чухал гэдгийг мэдэх, мөн хэрхэн, хэзээ хандах, хэнээс тусламж авч болох тухай мэдлэгтэй болох,
- Хүчирхийлэлд өртөхгүйн тулд, өөрийгөө хамгаалахын тулд юу хийх ёстой гэдгийг мэдэх, бусдадаа хэлж ойлгуулах,
- Хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэнд хандах ёстой, хэнээс тусламж дэмжлэг авах ёстой болохыг мэдэх,
- Хүчирхийлэлд үйлдэгчтэй харилцах үр дүнтэй аргуудын талаар мэдлэгтэй болох,
- Хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд үе тэнгийнхэний хамтаар хийж болох саналуудыг дэвшүүлэх, хэрэгжүүлэх г.м

Агуулга: хүчирхийлэл гэж юу болох, хүчирхийллээс хэрхэн урьдчилан сэргийлэх аргууд, хүчирхийлэл гарсан үед хэрэгжүүлбэл зохих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж чадах ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн байна. Түүнээс гадна түүх, уран зохиол, иргэншил хичээлийн агуулгын хүрээнд хүчирхийллийн эсрэг эсвэл хүчирхийлэлт бус дүр, хувь хүмүүсийн талаар заавал тусгах нь зүйтэй. Дайн, олон хүнийг хоморголон устгасан тухай түүхэн баримтыг хүнлэг энэрэнгүй ёсны үүднээс шүүмжлэлтэй хандаж агуулгадаа тусгавал зохино. Суралцагчдад холбогдох хуулиудын талаар мэдлэг олгож, гэмт зан үйл болон төлөвшихөөс урьдчилан анхаарах хэрэгтэй.

Аргазүйн хувьд: асуудлыг эв зүйтэйгээр, хамтран ажиллах замаар асуудлыг шийдэх, эрх мэдлийн эерэг болон сөрөг харилцаанд анхаарсан интерактив, шавь төвт сургалтын аргуудыг ашиглах нь зүйтэй. Мөн бодит амьдрал дахь хүчирхийллийн тохиолдлууд, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй хүчирхийлэлт үйл явдлуудад шүүмжлэлтэй хандах боломжийг суралцагчдад олгох ёстой.

Сургалтын хэрэглэгдэхүүний хувьд: Хүчирхийллийг тодорхой хэмжээгээр өгүүлсэн ном, сурах бичгийг ашиглахдаа зохих хүмүүнлэг үүднээс шүүмжилсэн тайлбарыг өгөх хэрэгтэй.



Үнэлгээ: Зохистойгоор биеэ авч явж буй, энх тайванч, бусадтайгаа эв зүйгээ олж чадаж буй сурагчдыг тэр даруйд нь урамшуулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл сурагчдын даалгавар биелүүлж буй мэдлэг, чадварыг үнэлэхээс гадна түүний биеэ авч явж буй зан үйлийг урамшуулан үнэлэх замаар хүчирхийллээс урьдчилан сэргийлж чадна.

1. Бага ангийн сурагчдыг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр (6-10 нас)

Сургуулийн бага насны хүүхдүүд нь хүчирхийлэлд өртөх магадлал өндөр байдаг. Иймд багш хүчирхийллээс хүүхдийг урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр боловсруулан иргэний боловсролын хүрээнд хичээл зааж болох юм. Тухайлбал, Бэлгийн хүчирхийллээс хүүхдийг урьдчилан сэргийлэх сэдвээр хичээл заахдаа хүүхдүүддээ дараах 3 зүйлийг зааж сургах хэрэгтэй.

- Хүүхдүүддээ түүний **биеийнх нь чухал эрхтэн хэсгүүдийг зөв нэрлэж чаддаг** болгон зааж өгөх. Хүүхдүүд ихэвчлэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухайгаа бусдад хэлэхдээ төвөгтэй байдаг. Учир нь тухайн эрхтэн хэсэг түүний үүргийн талаар ямар ч үг мэддэггүй. Хүүхэд биеийнхээ чухал хэсгүүдийн талаар анатомийн талаас нь зөв үг хэллэгүүдийг сурснаараа өөрийн биеийнхээ эрхтэн хэсгүүдийн талаар ярилцахад ямар нэгэн саадгүй хэвийн зүйл гэдгийг мэдэж авахад тус болдог.
- **Чи өөрийнхөө биеийн эзэн нь гэдгийг ойлгуулж** зааж өгөх. Хүүхдэд хэн биенд нь хүрч болох, яагаад хүрч байна гэдгийг хянах чадвартай болгох нь ихээхэн чухал.
- **Биед нь хүрсэн тохиолдолд татгалзах, болиулах эрхтэй гэдгийг ойлгуулах.** Хэрвээ хүүхэд хүсэхгүй байхад хамаатан садан ойр дотны хүмүүс хүүхдийн биед хүрэх тэврэх, үнсэх тохиолдолд дургүйцэх эрхтэйг хэлж ойлгуулах хэрэгтэй.

Багш хүүхдийн биед хэн нэгэн дараах гурван хэлбэрээр хүрдэг гэдгийг тайлбарлаж өгсөнөөр хүүхэд хүчирхийллээс өөрийгөө хамгаалах чадвартай болдог байна.

- **Аюулгүй хүрэлт.** Хүүхдийг хайрлах, хамгаалах, асрах үүднээс биенд хүрч байгаа тохиолдолд аюулгүй байна. Аюулгүй хүрэлтэд тэврэх, үүрэх, нуруу руу нь нөхөрсгөөр алгадах зэрэг нь багтана.
- **Аюултай хүрэлт.** Хэрэв бие махбодь болон сэтгэл санаанд таагүй нөлөөлөл үзүүлэх эсвэл өвтгөж байвал аюултай хүрэлт юм. Тухайлбал, цохих, түлхэх, нударх, өшиглөх зэрэг нь үүнд багтана. Иймэрхүү төрлийн хүрэлт нь **таатай бус** гэдгийг маш сайн тайлбарлаж өгөх хэрэгтэй.
- **Хүсээгүй хүрэлт.** Энэ нь аюулгүй байж болно. Гэхдээ хүүхэд тухайн агшинд тухайн хүнийг биендээ хүргэхийг хүсэхгүй байж болно. Иймд хүүхэд өөрөө хүсэхгүй байгаа нөхцөлд хэн нэгнийг биендээ хүрэхийг зөвшөөрөхгүй байж болно гэдгийг ойлгуулах нь зүйтэй. Ийм тохиолдолд хүүхдийг “үгүй” хэмээн эелдгээр татгалзаж сургах хэрэгтэй. Энэ нь хүүхдийн өөрийн хувийн хил хязгаарыг тогтоож сурахад тусална.

Мөн хүүхдэд биеэ авч явах, хүчирхийллээс урьдчилан

сэргийлэх дараах аюулгүйн дүрмийг зааж өгөх нь чухал юм.

- Хэн нэгний биеийн эмзэг хэсэгт хүрэх нь зохисгүй.
- Хэн нэг нь чиний өмнө биеийнхээ эмзэг хэсэгт хүрэх нь зохисгүй.
- Хэн нэг нь чамайг өөрийнхөө эмзэг хэсэгт хүрэхийг хүсэх нь зохисгүй.
- Хэн нэг нь чамайг хувцсаа тайлах, эсвэл хувцасгүйгээр чинь зургийг чинь авах, бичлэг хийх нь зохисгүй.
- Хэн нэг нь чамд нүцгэн хүний зураг үзүүлэх нь зохисгүй.

2. Дунд ангийн сурагчдыг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр (10-14 нас)

Дунд ангийн сурагчдад зориулсан сургалтын хөтөлбөр нь тэднийг бусдыг дарамтлах, аливаа асуудлыг хүчээр шийдвэрлэх, түрэмгий зан авиртай болохоос урьдчилан сэргийлэхэд чиглэх юм. Учир нь тэдний насны онцлогтой нь холбогдож байгаа билээ. Энэ нь хүүхдийн болчимгүй, ойворгон, онгиороо, түрэмгий зан үйлээ хэрхэн багасгах, сэтгэл хөдлөлөө зохицуулдаг болоход нь туслах юм. Сурагчдад тохиолдож болох эрсдэл, сэтгэл хөдлөлөө зохицуулах чадвар зэргийн талаар сурагчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, тэднийг хүчирхийллийн эсрэг зан үйл бүхий болон төлөвших тодорхой зорилго өөртөө дэвшүүлэхэд туслахад анхаарах ёстой. Уг хөтөлбөр нь дараах гурван чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ:

- **Сэтгэл хөдлөлөө ойлгох.** Сурагчид өөрсдийн болон бусдын сэтгэл хөдлөлийг ялган салгаж таньж мэдэхийг зааж сургах. Сэтгэлийн зовлонтой байх үед бусадтайгаа хэрхэн харилцах нь зохистой вэ гэдэгт сургах явдал юм.
- **Болчимгүй авир болон ойворгон зангаа хянах, асуудлыг оновчтой, зохистойгоор шийдвэрлэх.** Сурагчдад зөв замыг сонгох, зөв зорилготой байх, онгиороо хөөрүү зангаа хянах, дарах, өөрийн аюулгүй байдлаа хангах, бусадтай харилцахдаа эвтэй найртай байх зэрэгт нөлөөлөх юм.
- **Уур бухимдлаа хянах.** Сурагчид маш их уурласан үедээ сэтгэл хөдлөлөө зөвөөр илэрхийлэлж, зохицуулах, нөхцөл байдлыг хянах чадвартай болоход тусална.

Хөтөлбөр нь маш өргөн хүрээнд хэрэгжих боломжтой юм. Жишээ нь хүмүүс хоорондын зан харилцааны янз бүрийн нөхцөл байдлыг \хэрэлдсэн, зөрчилдсөн, зодолдож тэмцэлдсэн, хүч хэрэглэсэн г.м\ дүрслэн харуулсан фото зураг болон видео бичлэгийг ашиглан хичээлийг явуулж болох юм. Ингэхдээ хичээлийн зааварчилгаа, гарын авлага, ангийн хэлэлцүүлэг өрнүүлэх удирдамж зэргийг урьдчилан боловсруулсан байх нь зүйтэй. Хүүхдүүдэд гэрийн даалгавар өгч ажиллуулж болох бөгөөд дадлагад тулгуурлан чадавхжуулахад анхаарах хэрэгтэй байдаг. Мөн эцэг эхэд зориулсан удирдамж заавар, нэмэлт материал \захидал, видео бичлэг, сурах бичиг, гарын авлага г.м\ -ыг олговол илүү оновчтой. Жилд 20-25 хичээлийг энэхүү хөтөлбөрийн дагуу зааж чадвал ихээхэн ач холбогдолтой. Дунд ангийн сурагчдад хүчирхийлэл яагаад үүсдэг, шалтгаан нөхцөлүүд нь юу болох талаар хэлэлцүүлэг өрнүүлж хүчирхийллээс урьдчилан сэргийлэх



ямар арга замууд байж болох талаар ярилцан бие биеэ хүндэтгэх, хүчирхийлэлгүй сургуулийн орчинг бий болгох чадварыг нэгж хичээлийн хөтөлбөрөөр төлөвшүүлж болох юм.

3. Ахлах ангийнхан буюу шилжилтийн насны хүүхдүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр (14-18 нас)

Шилжилтийн насны хүүхдүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр нь хүүхдүүдэд хүмүүсийн хоорондын харилцааны хүчирхийллийн эрсдэлтэй хүчин зүйлийн талаар мэдээлэл өгөх, иймэрхүү асуудлыг нударга зөрүүлэхгүйгээр шийдвэрлэж байх чадвар олгоход чиглэгдэнэ. Хичээлийн хөтөлбөр нь дараах зорилгод чиглэнэ.

- Хүчирхийлэл бол зайлсхийж болох зүйл гэдгийг тайлбарлах
- Сурагчдад уур бухимдал бол амьдралын хэвийн үзэгдэл. Уур бухимдлыг барих, чиглүүлэх, зөв эрүүл ухаанаар зөв зохистой арга замуудаар шийдвэрлэх боломжтой гэдгийг ойлгуулах.
- Хүүхдүүдэд уур уцаараа хянаж сурах чадвар эзэмшүүлэх.
- Уураа барих зөв аргуудыг зааж өгөх.
- Зөрчилдөөнтэй нөхцөл байдлаас үүссэн хүчирхийллийг хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэхийг бодож тунгаан үзэх чадвартай болгоход чиглэнэ.

Энэхүү хөтөлбөрийг дараах хоёр хэлбэрээр хэрэгжүүлж болох юм.

- Сургалтын хөтөлбөрийг хүчирхийлэлд өртөмтгий бүлэг болон харьцангуй тайван бүлэгт хэрэгжүүлэх.
- Ахлах ангийн хүүхдүүдийг хамруулах. Сургуулийн хэмжээнд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх санаачилга өрнүүлэх, идэвхтэй үйл ажиллагаа явуулах, яриа таниулга хийх, уулзалт семинар зохион байгуулах.

4. Хүчирхийллийн асуудлаар хүүхэдтэй хэрхэн ажиллах хэрэгтэй вэ?

Ганцаарчилсан ярилцлагын арга

Та энэхүү аргыг хэрэглэхдээ хүүхдийг надтай хамт байхад аюулгүй гэдгийг хэлж мэдрүүлэх хэрэгтэй. Дараа нь түүний итгэлийг олж авна. Хэрэв хүүхэд тантай чөлөөтэй ярихгүй байгаа бол та түүний итгэлийг олж авч чадаагүй байна гэсэн үг. Олонх тохиолдолд уйгагүй олон удаагийн уулзалтын дараа хүүхэд танд итгэж эхэлдэг. Мөн хэнтэй ч хамаагүй илэн далангүй ярилцдаг хүүхдүүд цөөхөн тохиолддог.

Таны уйгагүй оролдлогын дүнд хүүхэд чөлөөтэй ярьдаг болно. Энэ бол их амжилт бөгөөд хамгийн том шалгуураа амжилттай давсны илрэл юм. Цаашид энэ хүүхэдтэй ажиллахад амар байх болно. Эхлээд та түүний дуртай сэдвээр яриагаа эхлээд сэдвийг аажим гэр бүл рүү хандуулна, гэвч бага насны хүүхэдтэй ярилцаж байх үед та аяндаа энэ сэдэв рүү хөтөлж оруулдаг. Мөн яриа

эхлээд удаагүй байхад тэд яриандаа гэр бүлийн маргааны тухай ямар нэгэн үг цухуйлгадаг. Энэ тухай ярих дургүй хүүхэд ч байдаг. Албадах хэрэггүй. Хэрэв хүүхэд ярих дуртай байвал:

- Тэр өдөр гэрт юу болсон тухай, эсвэл чамд юу тохиолдсон тухай надад яримаар байна уу, энэ тухай багшдаа яриач гэж хүснэ. Таны гол үүрэг бол сонсох бөгөөд мэдрэмжийг нь гаргуулах гэдгийг санаарай.

Өөрийн мэдрэмжийг гаргуулах тал руу ярилцлагаа чиглүүл хүүхэд юун тухай ярих, өөрөө юу мэдэрч байгаагаа үгээр илэрхийлж чадахгүй байж мэдэх тул та ярилцлагыг санаачил, ярихад нь дэмжлэг урам өг. Үүнд дараах асуултуудаас хэрэглэж болох юм.

- Чамайг хамгийн их айлгадаг зүйл юу вэ?
- Аав ээжийгээ зодолдох үед чи үйлддэг үү?
- Яагаад аав ээж чинь архи уудаг юм бол?
- Ах эгчид чинь ямар байдаг вэ?
- Тэд яадаг вэ?
- Архи уухаа болих бол уу?
- Чи юу хүсэж байна?
- Чи ээждээ аавдаа зориулж юу хэлмээр байна?
- Хүмүүст зориулж юу хэлмээр байна?

Ингээд ярилцлага дуусахаас 5 минутын өмнө хоёулаа одоо ярилцлагаа дуусгана гэдгийг сануулна. Яриагаа хөгжилтэй сэдвээр дуусгана. Уулзалтын дараа хүүхдийн хувийн хэрэгт ярилцлагыг тэмдэглэнэ.

Хүүхдийг дэмжих бүлгийн арга

Дэмжих бүлэг нь ганцаарчилсан уулзалт дууссан хүүхэдтэй үргэлжлүүлэн ажиллахын нэг хэлбэр юм. Хүүхдийн дэмжих бүлэгт нэг удаад 5-7 хүүхэд хамрагдахад тохиромжтой ба 12-20 курс хичээл байж болдог. Үүнээс бага ч байж болох юм. 7 хоногт хүүхдийн боломжоос хамаарч хэдэн удаа хичээллэхээ тогтооно. 1 удаа ч байж болно. Хичээл бүрт өмнөө тавьсан зорилготой байх ёстой.

Хүүхэд болон өсвөр үеийнхэнд бүдүүлэг хандаж хүчирхийлэх явдал нь сүүлийн жилүүдэд илт өсөх хандлагатай болж байна. Хүүхэд, өсвөр насны хүүхдийн хүчирхийлэлд ижил олон зүйл байгаа боловч өсвөр үеийнхний хүчирхийллийг тодорхойлох хэд хэдэн онцлог байдаг.

- Өсвөр насныхны хүчирхийлэлд өртөх хүрээ хүүхэд байх үеийнхтэй адилхан эсвэл ихээхэн хэтэрсэн байдалтай байдаг. Энэ нь хэвийн бус гэр бүлд өсөх, сурах дургүй болох, зугтаах, тэнэх зэрэг нэрийн дор явагдаж байдаг байна.
- Өсвөр үеийнхэнд хүүхдийн хүчирхийллийн бүх хэлбэр тохиолддог боловч биеийн хүчний хэлбэр харьцангуй бага харин сэтгэл санааны ба бэлгийн хүчирхийллийн хэлбэр хамгийн их байдаг байна. Ялангуяа 13-16 насны өсвөр үеийнхэнд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байх нь маш элбэг.
- Хүчирхийллийн өндөр эрсдэлд байгаа өсвөр насныхан үеийн найзуудаа бодвол эрх мэдэл багатай, хөгжлийн бэрхшээлүүд ихтэй байгаа нь харагддаг.

Жижиг багаар ажиллах арга

Багшийн зүгээс суралцагчдыг жижиг бүлэг багт хуваана. Дараа нь тодорхой сэдэв сугалуулах, асуудал



шийдүүлэх, төсөл боловсруулах зэрэг бүтээлч үйл ажиллагааг харуулах даалгавар өгч гүйцэтгүүлнэ. Багт тухайн бүлгийн гишүүн бүр тодорхой үүрэг хүлээхээр байх нь зүйтэй. Багшийн зүгээс жижиг багаар ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгөх нь зүйтэй. Үүний тулд 5 үндсэн асуудлыг анхаарч зохицуулах шаардлагатай.

- Эерэг харилцан хамаарал. Багийн гишүүд нэгдсэн зорилгыг биелүүлэхийн төлөө бие биетэйгээ холбоо хамааралтай гэдгээ мэдэрч байгааг хэлнэ.
- Хувийн үүрэг хариуцлага. сургалтын зорилгыг биелүүлснээ харуулах хариуцлагыг хүн болгон ухамсарлах ёстой
- Нүүр тулсан харилцаа. багын гишүүд хамтран сууж ярилцлага, хэлэлцүүлгийг өрнүүлэх боломжтой байх
- Нийгмийн харилцааны үр чадварууд. багын гишүүдийн хоорондоо харилцах чадварууд
- Боловсруулалт: багийн гишүүд өөрсдийн хамтын ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөн цаашдаа улам боловсронгуй болгох зорилт дэвшүүлэх

Эвлүүлгийн арга

Энэ аргыг хэрэглэхэд багаар ажиллах бөгөөд багийн гишүүн бүр судалж байгаа хичээлийн сэдвийн задаргаа ямар нэгэн агуулга, аспектаар эксперт болох юм. Жишээ нь: хамтран суралцаж байгаа баг “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл” сэдвийг судалж байгаа гэж үзвэл багийн нэг гишүүн нь “Хүүхдийг үл хайхрах” асуудлаар эксперт болон, гурав дахь нь “Сэтгэл санааны дарамтаар” эксперт болно. Хуваагдсан багуудын гишүүд өөр өөрсдийн чиглэлээр нийлж экспертийн багийг бүрдүүлнэ. Экспертийн багийн гишүүд хамтран оногдсон сэдвээ судалж мэдлэг туршлагаа ахиулсны дараа хамтран суралцах үндсэн багуудад эргэж нэгдэн ээлж ээлжээр бусдадаа хичээл заана. Ингэснээр багийн бүх гишүүн үндсэн асуудлаар мэдлэг ойлголттой болно.

Дээрх аргуудыг ашиглан хүүхэдтэй ажиллах талаар багш өөртөө итгэлгүй байвал нийгмийн ажилтны дэмжлэгийг авах шаардлагатай. Ингэснээр хүчирхийлэл гарсан тохиолдолд даруй арга хэмжээ авч ажиллах, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сэтгэлзүйн зөвөлгөө өгөх талаар хамтаран ажиллаж тодорхой үр дүнд хүрэх болно.

5. Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн үнэлгээ

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэр зэрэг амжилттайгаар хэрэгжсэнийг үнэлэхдээ тест, асуулга, ажиглалт, ярилцлага зэрэг аргуудыг ашигладаг. Хөтөлбөрийн үр дүнг илүү нарийвчлан тогтоохын тулд хөтөлбөрийн өмнөх болон хөтөлбөрийн дараах нөхцөл байдлыг хянаж тооцох илүү оновчтой. Түүнчлэн хувь сурагч, анги бүлэг, сургуулийн түвшинд хөтөлбөр ямар үр нөлөө авчирсан болохыг тогтоох нь чухал. Нийгмийн харилцааны үр чадвар, түрэмгий зан үйл, сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг үнэлэхдээ сэтгэлзүйчдийн боловсруулсан тестүүдийг ашиглах нь зүйтэй. Харин хүчирхийллийн талаарх ойлголт, мэдлэг, эерэг хандлага хэр зэрэг төлөвшсөнийг харахын тулд багш та өөрөө

тест боловсруулан үнэлж болох юм. Үнэлгээндээ дараах зүйлсийг анхаарна уу.

1. Бага ангийн түвшинд:

Урьдчилсан болон харьцуулсан тест авах (туршилт явуулж байгаа бүлэг, хяналтын бүлэгтэй сургуулийн хүрээнд)

Сургуулийн нөхцөл байдлыг гаднаас нь ажиглах. Сургуулийн анги танхим дотор болон сургуулийн орчин тойронд болж байгаа нийгмийн сөрөг зан үйл, түрэмгийлэл хэр зэрэг байгаа, ямар хэлбэр илэрч байгаад ажиглалт хийнэ.

Багш нарын дунд хүүхдүүдийн чадавч болон сөрөг зан үйлийн аливаа асуудлыг шийдвэрлэх чадварын түвшинг тогтооно.

2. Дунд болон ахлах ангийн түвшинд:

Хөтөлбөрт оролцсон оролцоогүй дунд болон ахлах ангийн сурагчдаас хөтөлбөрөөс өмнө, хөтөлбөрийн дараа гэсэн хоёр хэлбэрээр тест авч үнэлнэ. Энэ нь нийгмийн харилцааны үр чадвар, түрэмгий зан үйлийг зөвшөөрөх байдал, сэтгэл хөдлөлөө удирдах чадвар зэрэг нийгмийн цогц чадамжийн үзүүлэлт зэргээр тест хэлбэрээр авна.

3. Сургуулийн түвшинд:

- Хоорондоо тодорхой шинж тэмдгүүд нь тохирч байгаа (нэг дүүрэгт байгаа, улсын болон хувийн гэх мэт) 6 хос сургуулийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч үнэлгээ явуулна.

- Санамсаргүй түүврийн аргаар тохирсон хос сургуулийг харьцуулах байдлаар хүчирхийлэлийн нөхцөл байдал байгаа эсэхийг хянана. 16-20 долоо хоног явагдана. Явагдах хугацаанд 2 удаа ангиудыг хөтөлбөрийн чанар, хэрэгжилтийг шалгах зорилготой ажиглалт явуулна. Үнэлгээгээр гарах үр дүнг 3 үед ялган авч үзнэ.

- Хөтөлбөр эхлэхээс өмнө
- Хөтөлбөр эхэлсэнээс 2 долоо хоногийн дараа
- Хөтөлбөр дууссанаас хойш 6 сард

Хичээл орсон анги бүрээс 12 хүүхдийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авна. Сонгож авсан хүүхдүүд дээрээ 3 шаттайгаар ажиглалт хийнэ.

- Хөтөлбөр эхлэхээс өмнө 60 минут
- Хөтөлбөр эхэлсэнээс хойш 2 долоо хоногийн дараа 60 минут
- Хөтөлбөр дууссанаас хойших 6 сард 45 минутаар хүүхдүүдийг ангид, сургуулийн хоолны газар, тоглох үед нь тулсан ажиглалт хийнэ. Ажиглаж байгаагаа хүүхдэд мэдэгдэж болохгүй.

6. Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн нөөц хэрэглэгдэхүүнд юу анхаарах ёстой вэ?

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр нь сургалтын дараах нөөц хэрэглэгдэхүүнийг ашиглан явагдана.

Багшлах боловсон хүчний нөөц. Сургуулийн бүх багш нар удирдах ажилтан, ажилчдыг тусгай хөтөлбөрийн



хүрээнд хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулан бэлтгэнэ. Үүнийг сургуулийн ерөнхий төлөвлөгөөнд тусган, хэзээ, хэдэн цагаар явагдах ёстойг тогтооно.

Техник тоног төхөөрөмж. Хичээл нь гол төлөв видео бичлэг \DVD, VCD\ дээр тулгуурлаж явагдах тул ангид компьютер, принтер, телевизор, видео магнитофон, DVD player суурилуулан нийгмийн харилцааны олон талыг харуулсан бичлэг бүхий хуурцагуудыг бэлтгэнэ. Нийгмийн харилцааны олон талыг харуулсан бичлэгийг өөрсдөө зохиомжлохоос гадна бэлэн бэлтгэсэн сургалтын хуурцаг эсвэл кино, жүжгийн хэсгийг ашиглаж болох юм. Энэ нь тухайн зөрчилтэй асуудлыг бодит амьдрал дээр хэрхэн зөвөөр шийдвэрлэж байгааг сурагчид харж суралцахад

чухлаар нөлөөлнө.

Ном сурах бичиг. Хүчирхийлэлийн төрлүүдийн тухай, хүчирхийлэлд өртсөн үед авах арга хэмжээний тухай, хүчирхийллээс хүүхдийг хамгаалдаг байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагааны талаар бичсэн ном, тараах материал, зөвлөмжүүдийг хичээл заах ангидаа тавьж хүүхэд сонирхсон материалаа авч ашиглах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Үүний тулд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, тэндээс гаргаж байгаа ном, сурах бичиг, гарын авлагуудыг авч ашиглах нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чухлаар нөлөөлнө.

НОМЗҮЙ

1. Монголын хүүхдийн эрхийн төв “ЕБС-ын сургалтын хөтөлбөрт хүүхдийн эрхийн асуудлыг тусгах гарын авлага” УБ., 1997
2. НҮБ-ын Хүүхдийн сан, МУБИС, Хүний эрхийн боловсролын төв “Хүүхдийн эрхийн боловсрол” УБ., 2008
3. UNICEF “Child friendly schools” manual , New York, USA 2009
4. George T. Andreopoulos and Richard Pierre Claude , (1997) *Human Rights Education for the Twenty-First Century* University of Pennsylvania, Philadelphia
5. Eds. Nancy Flowers (1998) *Human Rights; Here and Now* Human Rights Educator’s Network, Amnesty International USA
6. Flowers, N. and RudeliusPalmer, K. (2000, July 25).An introduction to human rights education.